



ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН ТОГТООЛ

2023 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Зөвлөх үйлчилгээний тайлангийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай

Цөмийн энергийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, Цөмийн энергийн комиссын дүрмийн 3.5, 3.6, 4.1.2-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Олон Улсын Атомын Энергийн Агентлагаас “Ураны үйлдвэрлэлийн талбайд үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээ”-ний тайлангийн санал, зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Зөвлөх үйлчилгээний тайлангийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж, төлөвлөгөөний биелэлтийг улирал тутамд тайлагнаж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (Ж.Ганбаатар), Байгаль орчин, аялал жуулчлалын яам (Б.Бат-Эрдэнэ), Ашигт малтмал, газрын тосны газар (Л.Баярмандал), Боловсрол, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан, технологийн бодлого, инновацийн хөгжүүлэлт, хэрэгжилтийг зохицуулах газар (Д.Баттогтох), Боловсрол, шинжлэх ухааны яамны Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газар (Б.Батгэрэл), Цөмийн энергийн комиссын Ажлын алба (Г.Манлайжав), Шинжлэх ухааны академи (Д.Рэгдэл), “Мон-Атом” ХХК-ийн гүйцэтгэх захирал (Д.Далайжаргал)-д тус тус даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цөмийн энергийн комиссын Ажлын алба (Г.Манлайжав)-нд даалгасугай.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД,
КОМИССЫН ДАРГА



Л.ЭНХ-АМГАЛАН

Цөмийн энергийн комиссын 2023 оны
01 сарын 24-ны өдрийн 01 дугаар
тогтоолын хавсралт

ОУАЭА-ийн "УРАНЫ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТАЛБАЙД ҮНЭЛГЭЭ ХИЙХ" (URSAT) ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ТАЙЛАНГИЙН САНАЛ, ЗӨВЛӨМЖИЙН МӨРӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Шинжээчдийн зөвлөмж	Шинжээчдийн санал	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцагч	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
1	2	3	4	5	6	7
Ураны үйлдвэрлэлийн циклийн үндэсний стратегийг тодорхойлсон байх.						
2. Менежмент, удирдлага, зохион байгуулалт						
1	R-1.2.1 Үндэсний бодлого, холбогдох хууль эрх зүйн орчин нь уурхайг ашиглалтаас гаргах урьдчилсан төлөвлөгөөнд тусгагдсан зардлын тооцоонд үндэслэн операторын гаргах санхүүгийн баталгааг хангуулах шаардлагыг агуулсан байх. Санхүүгийн баталгаанд уурхайг хаах, хаалтын дараах хяналт мониторинг, эрх бүхий байгууллагын хяналт доорх урт хугацааны хяналт, засвар үйлчилгээний зардлууд хамаарч болох ба оператор нь уурхайг хаах, нөхөн сэргээх боломжгүй тохиолдолд Засгийн газарт төлөх ёстой зардал юм.		1.Цөмийн энергийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хуульд санхүүгийн баталгааг хангуулах шаардлагыг тусгуулах ажлыг зохион байгуулах; 2.Уурхайг хаах, хаалтын дараах хяналт мониторингийн зардлыг төрийн санд байршуулах тогтолцоог бий болгох; 3.Цөмийн энергийн тухай хуулийн 28.9 заалтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; 4.Оператор нь уурхайг хаах, нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүй тохиолдолд тус үйл ажиллагааг өөр байгууллагаар гүйцэтгүүлэх, дээрх сангаас санхүүжүүлэх зохицуулалтыг бий болгох.	2023-2024	УУХҮЯ	БОАЖЯ, СЯ, ЦЭК-ын Ажлын алба, АМГТГ, БШУЯ-ны Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газар, Орон нутгийн засаг захиргаа
2	Уран олборлох, боловсруулах эрх зүйн орчин, үндэсний зохицуулалтын дэд бүтэц нь сайн бүрдсэн байх. S-1.3.1 Ураны хайгуул, олборлолт, боловсруулалтын тусгай зөвшөөрлийн өргөдөл зэрэг зохицуулалтын үйл явцын талаарх удирдамжийг оператор болон холбогдох бүх оролцогч талуудад ойлгомжтой болгон сайжруулах шаардлагатай. Үүнийг ТЭЗҮ, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, Хөрөнгө оруулалтын гэрээ гэх мэт ураны хайгуул, олборлолт, боловсруулалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой олон шатны үйл явцыг (Шат дамжлагууд болон зөвшөөрөл олгох эсвэл холбогдох чиг үүргийг аль нэг эрх бүхий байгууллага хариуцах) тоймлон харуулсан схем бүхий иж бүрэн зааварчилгааны гарын авлагыг боловсруулах замаар хийж болно.			2023	ЦЭК	УУХҮЯ, БОАЖЯ, АМГТГ, БШУЯ-ны Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газар, Орон нутгийн засаг захиргаа

3	S-1.3.2 Цөмийн энергийн тухай хууль болон Ашигт малтмалын тухай хуулийг хянан үзэж, ураныг олборлох боловсруулах үйл ажиллагаатай холбоотой заалтын давхардал, хийдлийг арилгах	1. Цөмийн энергийн тухай хууль болон Ашигт малтмалын тухай хуулийг хянан үзэж, цацраг идэвхт ашигт малтмалтай холбоотой заалтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах; 2. Давхардал, хийдлийг хянах, арилгах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж, "Хийдлийн анализ" хийх.	2023	ЦЭК	УУХҮЯ, БОАЖЯ, АМГТГ, БШУЯ-ны Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газар, Орон нутгийн засаг захиргаа
4	R-2.2.1 Ураны хайгуулаас эхлэн уурхайг ашиглалтаас гаргах хүртэлх бүхий л процессыг зохицуулах, хянах үйл ажиллагааг үр дүнтэй явуулахад шаардлагатай мэдлэг, туршлага, ур чадварыг бий болгох, хангахын тулд холбогдох бүх эрх бүхий байгууллагуудын албан тушаалтнууд, техникийн дэмжлэг үзүүлэх байгууллагууд (жишээлбэл, Монголын Шинжлэх Ухааны Академи) зориулсан сургалтын системчилсэн хөтөлбөр (SAT)-г боловсруулж хэрэгжүүлэх. Энэ хүрээнд албан хаагчдын нийгмийн хангамж, түүнийг шийдвэрлэх стратегийг боловсруулж, хэрэгжүүлэх замаар тэдгээрийг тогтвор суурьшилтай ажиллуулахад анхаарах.	4. Сургалт, мэргэшил 1. Салбарын хүний нөөцийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах, оролцогч талуудыг тодорхойлж санхүүжилтийг шийдвэрлэх; 2. Цөмийн салбарын хүний нөөцийн сүлжээг бий болгох, салбарын хүний нөөцийн нэгдсэн мэдээллийн сантай болох; 3. Цөмийн технологи болон цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаа, цацрагийн аюулгүй байдлын чиглэлээр дээд боловсролын дараах мэргэшүүлэх сургалтын хөтөлбөртэй болох ажлыг зохион байгуулах; 4. Цөмийн технологи болон цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаа, цацрагийн аюулгүй байдлын чиглэлээр мэдлэгийн менежментийг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх; 5. Салбарт ажиллагчдын нийгмийн баталгаа, цалин хөлсний асуудлыг судлан шийдвэрлэх; Сургалтын системчилсэн аргачлалыг боловсруулж нутагшуулах ажлыг зохион байгуулах.	2023-2024	ЦЭК	УУХҮЯ, БШУЯ, БШУЯ-ны Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газар, Мэргэжлийн холбоо, ТББ
5	Орон нутгийн ГДУО гидрогеологи, уусгагчийн процессыг хангалттай загварчилсан ГДУО туршилтын олборлолтыг дэмжсэн. S-3.2.1 Эрх бүхий байгууллагууд нь бүс нутгийн болон орон нутгийн гидрогеологийн загваруудаар тодорхойлогдсон усны урсгалыг сааруулагч ус үл нэвчүүлэгч шаврын үе (Aquitards) дэх тасалдлаас үүссэн уст давхарга хоорондын нөлөөлөлд хяналт тавих. Энэ нь техникийн болон ундны усны эх үүсвэр болгон ашигладаг дээд уст давхаргаас доод уст давхарга дахь олборлолтын давхрага тусгаарлагдсан гэдгийг баталгаажуулахад тус болно. Гүний усны дээшлэлт болон урсацыг тодорхойлоход хагарлын (crosscutting	1. ОУАЭА-аас энэ чиглэлээр мэргэшсэн шинжээчид авч, гүний усны хяналт хийх чиглэлд байцаагчдыг мэргэшүүлэх, хяналтын механизмыг бий болгох ажлыг зохион байгуулах; 2. Олборлолтын, хяналтын загварчлалын программ хангамжийг бий болгох, нэвтрүүлэх арга хэмжээ авах. Уст давхарга хоорондын нөлөөлөлд хяналт тавим, хагарлын дагуу гүний усны дээшлэлт болон урсацыг тодорхойлж, хянах	2023-2024	УУХҮЯ	БОАЖЯ, ЦЭК, АМГТГ, БШУЯ-ны Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газар, ШУА, Усны газар Мэргэжлийн холбоод, Төрийн бус байгууллага, Нөлөөллийн бүсэд

	faults) -ийн үүргийг тодорхойлох шаардлагатай.	1. Уст давхарга хоорондын тусгаарлалтыг сайтар шалгах бичил чичирхийлэл зэрэг геофизикийн арга техникийг нэвтрүүлэн ашиглах.			амьдардаг иргэдийн төлөөлөл
6	S-3.2.2 Уурхайн олборлолтод зориулагдсан давжилт ихтэй доод уст давхарга ба техникийн болон ундны усны эх үүсвэр болгон ашиглаж буй түүний дээгүүрх давжилт багатай дээд уст давхаргыг тусгаарласан усан сан дахь мэдээлэгдсэн тасалдалд илүү сайн хязгаарлалтыг бий болгохын тулд чичирхийлэл зэрэг геофизикийн зохих арга техникийг ашиглах. Энэ нь гүний ус дээшлэх, урсахад усны урсгалыг сааруулагч ус үл нэвчүүлэгч шаврын үеийн хөндлөн огтлолын эвдрэл хагарлын (including crosscutting faults) гүйцэтгэх боломжит үүргийг тодорхойлоход хэрэгтэй юм.		2023-2024		БОАЖЯ, БШУЯ, АМГТГ, ЦЭК, БШУЯ-ны Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газар, ШУА, Усны газар, Төрийн бус байгууллага, Нөлөөллийн бүсэд амьдардаг иргэдийн төлөөлөл
		8. Уран олборлолт, боловсруулалтын инженерчлэл			
7	Бүсийн гидрогеологи, ГДУО, уусгагч уусмалын процессыг загварчилахад нарийвчилсан уурхайн төлөвлөлтөд хангалттай дэмжлэг хэрэгтэй. R-6.2.1 Үндсэн үйлдвэрлэлийн уурхайн төлөвлөгөө нь туршилтын олборлолтын торлолын хэлбэр, параметрууд болон геологийн тогтоцод үндэслэсэн эсэхийг холбогдох эрх бүхий байгууллагууд баталгаажуулах.	1. ОУАЗА-аас шинжээч авч, заавар зөвлөгөө авах; 2. Туршилтын өгөгдөл, үр дүн, параметруудыг үндсэн үйлдвэрлэлийн тооцоололд оруулсан эсэхийг нягтлах, ТЗЗУ-ийн тодотголд тусгуулах, ЭБМЗ-өөр хэлэлцүүлэх асуудалд тусгуулах ажлыг зохион байгуулах.	2023-2024	ЦЭК	УУХУЯ БОАЖЯ АМГТГ БШУЯ-ны Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газар
8	R-6.2.2 Холбогдох эрх бүхий байгууллагууд үндсэн олборлолтын үйл ажиллагааны үеийн гидрогеологи болон химийн бодисын зөөгдлийн загварчлал нь тухайн орон нутгийн шинж чанар, тооцоолсон загвар дээр үндэслэсэн эсэхийг баталгаажуулсан байх. Энэ мэдээлэлд уст давхаргыг урт хугацаанд ашиглахтай холбоотой мэдээлэл, мөн уурхайг хаах, гүний усыг нөхөн сэргээх шалгуурыг тогтоох шийдвэр гаргахад шаардлагатай усны чанарын талаарх мэдээлэл хамаарна.	1. Газрын дор уусган олборлох үйл ажиллагаанд ашиглах гидрогеологийн болон урвалж зөөгдлийн кодыг хянан үзэж, эдгээр нь талбайн өгөгдлүүд болон болон торлолын төлөвлөлт дээр үндэслэсэн эсэхийг шалгах; 2. ОУАЗА-аас олон улсын шинжээч авч, заавар зөвлөгөө авах; 3. Гидрохими болон урвалж зөөгдлийн талаар хяналт, мониторинг, үнэлгээ хийх чадавхийг бэхжүүлэх; 4. ТЗЗУ-ийн тодотголд тусгуулах, ЭБМЗ-өөр хэлэлцүүлэх асуудалд тусгуулах ажлыг зохион байгуулах.	2023-2024	УУХУЯ, ЦЭК	АМГТГ, БОАЖЯ, Усны газар, БШУЯ-ны Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газар,
9	R-6.2.3 Эрх бүхий байгууллагууд нь операторын үндсэн үйлдвэрлэлийн дараах химийн бодисын зөөгдлийн загварчлалд техникийн нарийвчилсан шинжилгээ хийх замаар хяналттай байгалийн нөхөн сэргээлт (monitored Natural Attenuation), сайжруулсан байгалийн нөхөн сэргээлт эсвэл идэвхтэй аргын сэргээлт зэргийг ашиглан	1. ОУАЗА-аас олон улсын шинжээч авч, заавар зөвлөгөө авах; 2. Гидрохими болон урвалж зөөгдлийн кодын тооцоолол, туршилтын дүн, үндсэн үйлдвэрлэлийн гидрохими болон урвалж зөөгдлийн тооцоололд бүрэн үнэлгээ хийж, уурхайг хаасны дараа гүний усыг нөхөн сэргээх идэвхтэй, идэвхгүй аргыг тодорхойлох.	2023-2024	УУХУЯ, БОАЖЯ, ЦЭК	АМГТГ, ШУА, Усны газар, БШУЯ-ны Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газар

	гүний усан санг сэргээх зорилгод хүрэх эсэхийг нягталж байх.		3. ТЭЗҮ-ийн тодотголд тусгуулах ажлыг зохион байгуулах.		
	Богино, дунд, урт хугацааны уурхайн төлөвлөлтийг хийдэг.				
10	R-6.3.1 Холбогдох эрх бүхий байгууллагууд тухайн уурхайн үндсэн үйлдвэрлэлийн төлөвлөлт, ашиглалт нь тусгай зөвшөөрөл, бусад шаардлагатай шаардлагыг хангасан эсэхийг нягтлах. Цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын зөвшөөрөл болон бусад шаардлагатай бүх зөвшөөрлүүд нь тодорхой, цаг хугацаандаа олгогддог байх. Зөвшөөрлийг олгох, сунгах процесс нь цаг хугацаандаа хэрэгжих, хэрэгжүүлэлт нь тодорхой байх.		1. ЦИИМ-тай холбогдолтой тусгай зөвшөөрөл болон бусад холбогдох тусгай зөвшөөрөл олгох, сунгах үйл ажиллагааны зураглал, бүрдүүлэх баримт бичиг, тэдгээрийн шаардлага, материалд үнэлгээ хийх хугацаа зэргийг тодорхойлсон сонирхогч талуудад зориулсан зөвлөмж, гарын авлага боловсруулах; 2. Зохицуулалтгүй байгаа Тусгай зөвшөөрлийг олгох процессийн талаар судалгаа хийж "Олон улсын туршлага" зөвлөх үйлчилгээ авах.	2023-2024	ЦЭК АМГТГ УУХҮЯ, БОАЖЯ, БШҮЯ-ны Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газар ТЕГ
11	R-6.3.2 Засгийн газар болон оператор нь тус тус үндсэн чиг үүргийн хүрээнд үйлдвэрлэл эхлэхээс өмнө бүс нутаг болон орон нутгийн дэд бүтцийг бий болгоход анхаарах. Үүнд: тээврийн сүлжээ, (төмөр зам, автомашины зам), цахилгаан эрчим хүчний сүлжээ гэх мэт болно. Энэ дэд бүтэц нь уурхайн үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн байна. Шаардлагатай тоног төхөөрөмж, материал, түүний дотор химийн бодис урвалжийн хангамжийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн стратеги боловсруулах.		1. ТЭЗҮ-ийн тодотголд тусгуулах ажлыг зохион байгуулах; 2. Уурхай хүлээн авах комисс, барилга байгууламж ашиглалтад хүлээн авах комисс ажиллуулж санал, зөвлөмж авах; 3. Орон нутагтай хамтран ажиллах гэрээ байгуулах; 4. Дэд бүтэц, хяналт шалгалт, аюулгүй байдалд чиглэсэн стратеги боловсруулах ажлыг зохион байгуулах.	2023-2024	УУХҮЯ БОАЖЯ, ЗТХЯ, БХБЯ, ЭХЯ АМГТГ, ЦЭК
10. Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаа					
	Ажиллагсад болон олон нийтийн цацрагийн хамгаалалтын эрх зүйн зохицуулалтыг тодорхойлсон.				
	R-7.1.1 Цөмийн энергийн тухай хууль болон холбогдох дүрэм, журамд "цөмийн бодис", "цацраг идэвхт материал", "цацраг идэвхт ашигт малтмал" гэсэн нэр томъёонууд байдаг боловч эдгээр нэр томъёог холбогдох эрх бүхий байгууллагууд нэг утгатай ашигладаггүй. Иймээс эдгээр нэр томъёог тодорхой болгож, тусгай зөвшөөрөл олгох үед эдгээрийг нэг утгатай хэрэглэх.		1. Цөмийн энергийн тухай хууль дахь нэр томъёоны тодорхойлолтод нэмэлт, өөрчлөлт оруулах; 2. Цөмийн энергийн тухай хууль болон холбогдох дүрэм журмыг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах;		ЦЭК, БШҮЯ-ны Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газар УУХҮЯ, БОАЖЯ, АМГТГ
12				2023-2024	

		тогтоосон журмын дагуу нийт альфаг тоолох зэрэг аргыг хэрэглэнэ.				
	R-7.1.2 Цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, олборлолт, боловсруулалтын шатанд ажиллаж буй цацрагтай ажиллагсдын цацрагийн шарлагын нэмэлт тунг (жишээлбэл, тоосонд байх цацраг идэвхт бодисоор амьсгалах, радоны задралын бүтээгдэхүүнээр амьсгалах) үндэсний тунгийн бүртгэлд оруулах.	S-7.1.2 Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны хяналтын асуудал хариуцсан албан тушаалтан нь цацраг идэвхт ашигт малтмалын олборлолт, боловсруулалтын онцлогт тохирсон цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангуулах, хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг (сургалтын системчилсэн хөтөлбөрт тулгуурлан) боловсруулах, хэрэгжүүлэх талаар авч үзэх шаардлагатай.	1. Цацраг идэвхт тоос, тоосонцорт агуулагдах уран, тори болон тэдгээрийн задралын бүтээгдэхүүний хувийн идэвхийг хянах болон радоны задралын бүтээгдэхүүнээр амьсгалах гэх мэт дотоод шарлага үүсгэх эх үүсвэр, шарлагын замыг тооцоолох, дотоод шарлагын тунгийн бүртгэлийг бий болгох; 2. Мэргэжлийн шарлагын хувийн тунгийн хяналтын чадамжийг сайжруулах; 3. ОУАЭА-ийн Мэргэжлийн шарлагын цацрагийн хамгаалалт (Occupational Radiation Protection Appraisal Service-ORPAS)-ын чиглэлээр экспертний үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулах; 4. Цацраг идэвхт ашигт малтмалын олборлолт, боловсруулалтын цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг хангуулах, хяналт тавих албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөр бий болгож, хэрэгжүүлэх. 5. Ажлын байрны агаар, тоосонцорт урт настай альфа цацраг идэвхт изотоп тодорхойлох, нийлбэр альфа болон бетта цацрагийг тоолох, радон болон түүний задралын бүтээгдэхүүнийг хэмжих, радиометрийн шинжилгээ хийх чадавхийг бий болгох.	2023-2024	БШУЯ-ны Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газар	ЦЭК
13						
	Оператор нь ажилчдын болон олон нийтийн цацрагийн хамгаалалтын талаар хүлэсэн үүргээ ойлгож, биелүүлдэг.	S-7.2.1 Цацрагийн хяналтын багаж, хэрэгслийг ашиглан олон төрлийн параметруудийг хэмжих боломжтой байдаг. Оператор болон эрх бүхий байгууллагууд тухайн багаж, хэрэгслийн төрөл тус бүр нь ямар үзүүлэлтийг тодорхойлж байгаа талаар нэгдсэн ойлголтой байх нь чухал юм. (тоосны дээж авахдаа үүссэн цацраг идэвхт изотопуудад анхаарал хандуулах шаардлагатай).	1. Хүн ам болон цацрагтай ажиллагчдыг цацрагийн шарлагаас хамгаалах хяналт мониторинг хийх хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах; 2. Цацраг хэмжих хэрэгсэл болон дотоод, гадаад шарлагыг тодорхойлох багаж, хэрэгслийн хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх, холбогдох албан хаагчдыг сургаж, дадлагажуулах; 3. Цацрагтай ажиллагчид болон хүн амын цацрагийн хамгаалалтын талаар хүлэсэн үүрэг хариуцлагын хүрээнд энэ чиглэлийн хяналт шинжилгээг гүйцэтгэх чадамжтай лаборатори бий болгох асуудлыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид үүрэг болгох.	2023-2024	ЦЭК, БШУЯ-ны Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газар	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид
14						
	Цацраг идэвхт материалыг аюулгүй тээвэрлэх хүрээ нь ОУАЭА-ийн Цацраг идэвхт материалыг аюулгүй тээвэрлэх журам (SSR-6)-д нийцэж байна.	1. Операторт зориулсан ОУАЭА-ийн аюулгүй ажиллагааны цуврал SSR-6-ын дагуу шар нунтаг бүхий ачаанд тавигдах шаардлага болон аюулгүй тээвэрлэхэд	2023-2024	ЦЭК	БШУЯ-ны Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газар.	
15	R-7.4.1 Цацраг идэвхт ашигт малтмалын олборлолт, боловсруулахтай холбоотой цацраг идэвхт материалыг тээвэрлэх					

	үйл ажиллагаа (жишээ нь: цацраг идэвхт дээж, шар нунтаг эсвэл цацраг идэвхт бодисоор бохирдсон материал)-г үндэсний хууль тогтоомжид тодорхой томъёолж, тусгах. Энэ хүрээнд ОУАЗА-ийн аюулгүй ажиллагааны цуврал SSR-6-ын дагуу цацраг идэвхт материалыг аюулгүй тээвэрлэхэд тавигдах шаардлагыг тодорхой тусгасан (шар нунтаг бүхий ачаанд тавигдах шаардлага болон аюулгүй тээвэрлэхэд тавигдах шаардлага) гарын авлага боловсруулах.		тавигдах шаардлагыг тодорхой тусгасан гарын авлагийг боловсруулах; 2. Хил, гаалиар нэвтрүүлэх үед мөрдөх аюулгүйн болон бусад заавар зөвлөмжийг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэх.		ГЕГ ХХЕГ
12. Оролцогч талуудын оролцоо					
16	Нээлттэй, ил тод оролцогч талуудын оролцооны хөтөлбөрийг боловсруулсан. S-9.1.1 Засгийн газар, эрх бүхий байгууллагууд оператороос ялгаатай харилцаа холбооны чиг үүргүүдээ тодорхой болгож, оролцогч талуудын хамтын ажиллагааг хангах, мэдээлэл хийх, уялдуулан нийтэй харилцах мэргэжилтэн, эсвэл алба, хэлтэс бий болгох. Олон нийтийн оролцоог үр дүнтэй бий болгох, сургахад шаардлагатай үр чадварыг мэргэжлийн харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн сургалтаар дамжуулан хөгжүүлэх шаардлагатай.	S-9.1.1.1 Зохихуулалт, хамтын ажиллагааны боломжуудыг тодорхойлохын тулд зохицуулах байгууллага бүрээс тусгайлан оролцогч талуудтай харилцах багийг бүрдүүлж, тогтмол уулзаж байх шаардлагатай.	1. Оролцогч талуудын хамтын ажиллагааг хангах, мэдээлэл хийх, уялдуулан зохицуулах, олон нийттэй харилцах алба, хэлтэс бий болгох; 2. Мэдээллийн ил тод байдлыг хангуулахад цөмийн салбарын оролцогч талуудад нэгдсэн мэдээллийн талбарыг хөгжүүлэх (олон нийтийн сүлжээ, албаны мэдээллийн хуудас); 3. Олон нийтийн мэдээллийг дээшлүүлэх мэдээллийн сувгийг хөгжүүлэх (ЕБС, Их дээд сургууль, судалгааны байгууллага, мэргэжлийн холбоо, орон нутаг, ААН).	2023-2024	УУХҮЯ, ЦЭК БОАЖЯ, БШУЯ, БШУЯ-ны Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газар, Орон нутгийн захиргаа Мэргэжлийн холбоод, ТББ
17	Дотоод болон гадаад харилцаа холбоог уялдуулах зорилгоор оролцогч талуудын оролцооны стратегийг хэрэгжүүлж, зохицуулна. R-9.2.1 Зохицуулах байгууллага болон оператор нь оролцогч талуудтай хамтран ажиллах стратегия боловсруулах шаардлагатай. Зохицуулах байгууллагууд гол асуудлууд, харилцааны үйл ажиллагаа, олон нийттэй харилцах харилцааны дотоод болон гадаад асуудлуудыг уялдуулах ёстой. Уран олборлох үйлдвэрлэл хөгжиж, шинэ асуудлууд гарч ирэхийн хэрээр стратегийг эргэн харж, шинэчлэх ёстой.	S-9.2.1: Эрх бүхий байгууллагууд цахим хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл дамжуулалтыг үргэлжлүүлэн хөгжүүлэх, мөн хоёр талт яриа хэлэлцээ болон шинжлэх ухаанд суурилсан тулгуур асуудлыг таниулах бусад мэдээллийн хэрэгслийг ашиглах, боломжуудыг бий болгох талаар анхаарах.	1. Талуудын оролцоо, уялдаа холбоог хангасан стратеги боловсруулах ажлыг зохион байгуулах; 2. Орон нутагтай хамтран ажиллах гэрээ байгуулах; 3. Олон нийтэд мэдээллийг хүргэх давтамжийг бий болгож, мэдээлэл хүргэж байгаа эсэхийг хянах журам боловсруулах ажлыг зохион байгуулах.	2023-2024	УУХҮЯ, БОАЖЯ, АМГТГ, БШУЯ-ны Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газар, Тусгай зөвшөөрөл эзэмшигчид
18		S-9.2.2: Эрх бүхий байгууллагууд оролцогч талуудын схемийг боловсруулахдаа оролцогч бүх талуудыг тодорхойлох ба харилцаа холбооны хэрэгсэл, гарц нь зорилтот бүлэгт тохирсон байх ёстой. Оролцогч талуудын шинэчилсэн санал асуулга эсвэл бусад төрлийн олон нийтийн санаа бодлыг судлах нь одоогийн олон нийтийн санаа бодлыг үнэлж, оролцогч	1. Олон нийтийн санаа бодлын асуумж бүхий судалгаа хийх ажлыг зохион байгуулах; 2. Нутгийн иргэд, олон нийттэй мэдээлэл солилцох, харилцан ярилцах уулзалтыг (диалог яриа) тогтмол зохион байгуулж байх.	2023-2024	УУХҮЯ, БОАЖЯ, АМГТГ, БШУЯ-ны Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газар, Тусгай зөвшөөрөл эзэмшигчид

	талуудын оролцооны стратегид мэдээлэл өгөхөд ач холбогдолтой.				
	14. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (суурь судалгаа багтсан)				
	Байгаль орчны үнэлгээний судалгааны журмын бүтцийг бий болгож, хэрэгжүүлж байна.				
19	S-10.1.1: Эрх бүхий байгууллагаас агаар, ус (үний болон гадаргын), хөрс, ургамал, амьтны аймаг дахь цацрагийн нөлөөллийг тусгайлан үнэлэхийн тулд ураны олборлолт, үйлдвэрлэлийн байгууламжийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд хамааралтай оператор компани (эсвэл түүний зөвлөх)-д химийн элементүүдийн концентрацид гарч болзошгүй өөрчлөлтүүд болон тэдгээр өөрчлөлтийн нөлөөллийг үнэлэх зэргийг оруулсан ажлын хамрах хүрээ болон явцыг багтаасан ажлын даалгаврыг боловсруулан гаргах.	1. Агаар, ус, хөрс, ургамал, амьтны аймаг дахь цацрагийн нөлөөллийг үнэлэх ажлын даалгавар боловсруулах ажлыг зохион байгуулах.	2023-2024	БОАЖЯ	Усны газар, ЦЭК
20	S-10.1.2: Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх хуулийн этгээдийн (зөвлөх компани) зөвшөөрлийн хүрээнд ураны олборлолт, үйлдвэрлэлийн байгууламжийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн хүрээнд цацрагийн чадамжийн стандартыг бий болгох (Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль).	1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулинд тусгах ажлыг зохион байгуулах; 2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэргэжлийн зөвлөлөөс санал авах.	2023-2024	БОАЖЯ	ЦЭК
	16. Хүрээлэн буй орчны хяналтын хөтөлбөр				
21	S-11.2.1: Монгол Улсын Засгийн газраас ШУА-ийн харьяа хүрээлэнгийн дэргэд уран олборлолтын үйл ажиллагааны байгаль орчны болон цацрагийн үнэлгээ хийх шинжлэх ухааны зөвлөх хороог байгуулах.	1. Жил бүр тасралтгүй хяналт, мониторинг хийх, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах; 2. Мэдээллийн сан бий болгох.	2023-2024	ШУА	УУХУЯ, БШУЯ, БОАЖЯ, ЦЭК
	18. Хаягдлын менежмент, нөхөн сэргээлт, уурхайн хаалтын төлөвлөгөө				
22	Уран олборлох, боловсруулах байгууламжийн байгалийн цацраг идэвхт материалын үлдэгдэл, хаягдлыг хүн ам, хүрээлэн буй орчноос хамгаалах зорилгоор зохион байгуулдаг.	1. Ажлын төлөвлөгөө, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт, шалгалтаар дүрмийн биелэлтийг тогтмол хянаж, шалгаж, үнэлгээ хийх;	2023-2024	БШУЯ-ны Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газар	ЦЭК АМГТГ
23	Ураны уурхай, боловсруулах байгууламжийг ашиглалтаас гаргах, нөхөн сэргээх, хаах төлөвлөгөөг бүтээн байгуулалтаас өмнө болон ашиглалтын бүх хугацаанд авч үздэг.	1. Уран олборлох, боловсруулах үйлдвэрийг хаах, нөхөн сэргээх талаар журам боловсруулах;	2023-2024	УУХУЯ	БОАЖЯ, ЦЭК, АМГТГ

уялдсан журам боловсруулах, үүндээ байгаль орчин, хүн амыг хамгаалахтай холбоотой уурхай болон боловсруулах үйлдвэрийн хаалтын дараах шалгууруудыг тусгах.		2. Тавигдах шалгуурыг тогтоож, Цөмийн энергийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хуульд тусгуулах ажлыг зохион байгуулах.			БШУЯ-ны Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газар
20. Чанарын үйлчилгээ					
Үндэсний Засгийн газраас үйлдвэрлэлийг дэмжиж, чанартай аналитик үйлчилгээг олгодог.					
24	S-14.2.1: Ураны олборлолт, боловсруулалттай холбогдох лабораториудийн чадавхыг улсын хэмжээнд бүртгэж, нөөцийг оновчтой болгох, туршлага солилцох зорилгоор агентлаг хоорондын хамтын ажиллагааг сайжруулах.	1. ОУАЭА-аас олон улсын шинжээч авч, Геологийн төв лабораторийн чадавхид үнэлгээ хийж, нөөц, чадавхыг бэхжүүлэх талаар ажлыг зохион байгуулах; 2. Шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалтыг гаргаж, тэдгээр төхөөрөмжүүдийн зах зээлийн судалгааг хийх.	2023-2024	БШУЯ ЦЭК	УУХҮЯ, БОАЖЯ, АМГТГ, БШУЯ-ны Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газар

XXXXXX